



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Ундарга-Алтай аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/006/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Атарцэцэг
Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn
Аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.13 № 10Н

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ундарга-Алтай ААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг батлуулан үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 96.0 хувиар биелүүлж, 206,133.3 мянган төгрөгийн ашигтай ажиллажээ.

Аймгийн төвд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн 150,000.0 мянган төгрөгийн аймгийн төвийн 3 автомат худгийг хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 8,704.0 мянган төгрөгийн компьютер, 15,000.0 мянган төгрөгийн хуванцар хоолойг гагнаж наах зориулалттай гагнуурын аппарат, 19,000.0 мянган төгрөгийн суудлын авто машиныг тус тус худалдан авсан байна.

8225020292

Бусад асуудал

Тайлант онд 8 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 14 арга хэмжээг бүрэн, 3 арга хэмжээг 90.0 хувь, 1 арга хэмжээг 70.0 хувь буюу нийт дүнгээр 96.6 хувиар биелүүлж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн, ажлыг үнэлээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,320,3746.19.	67,911,383.45
1.1.02	Дансны авлага	854,884,211.53	933,659,284.42
1.1.06	Бараа материал	17,787,881.72	31,666,700.06
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	875,992,467.44	1,033,237,367.93
1.2.01	Үндсэн хөрөнгө	5,579,230,880.45	5,428,786,782.65
1.2.02	Биет бус хөрөнгө	41,221,485.41	41,023,739.29
1.2.03	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,620,452,365.86	5,469,810,521.94
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,496,444,833.30	6,503,047,889.87
2.1.1.01	Дансны өглөг	303,492,636.83	344,986,943.62
2.1.1.02	Цалингийн өглөг	-	-
2.1.1.03	Татварын өр	70,716,754.88	81,620,908.50
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.05	Богино хугацаат зээл	4,013,763,882.65	3,761,835,218.65
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,387,973,274.36	4,188,443,070.77
2.1.2.01	Урт хугацаат зээл	34,027,409.83	34,027,409.83
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	34,027,409.83	34,027,409.83
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,422,000,684.19	4,222,470,480.60
2.3	- хувийн	3,387,570,457.62	3,387,570,457.62
2.3.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,760,414.97	59,760,414.97
2.3.2	Эздийн өмчийн бусад хэсэг	25,880,000.00	25,880,000.00
2.3.3	Хуримтлагдсан ашиг	(1,398,766,723.48)	(1,192,633,463.32)
2.3.4	Тайлангийн үеийн ашиг	131,730,460.60	206,133,260.16
2.3.5	Өмнөх үеийн ашиг	(1,530,497,184.08)	(1,398,766,723.48)
2.3.6	Эздийн өмчийн дүн	2,074,444,149.11	2,280,577,409.27
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,496,444,833.30	6,503,047,889.87

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,498,814,488.00	2,630,000,731.66
2	Борлуулалтын өртөг	2,047,335,501.66	2,292,777,564.50
3	Нийт ашиг(алдагдал)	451,478,986.34	337,223,167.16
8	Бусад орлого	33,877,798.38	8,010,000.0
8.1	Орлогын дүн	33,877,798.38	8,010,000.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	256,081,253.81	223,230,532.75
11	Санхүүгийн зардал	67,320,599.68	0
12	Бусад зардал	15,504,264.00	21,814,898.80
12.1	Зардлын дүн	338,906,117.49	245,045,431.55
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(83,488.79)	(21,150,779.88)
17	Бусад хөрөнгө		150,000,000.0
17.1	Олз, гарзын дүн	(83,488.79)	(128,849,220.12)

18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	146,367,178.44	229,036,955.73
19	Орлогын татварын зардал	14,636,717.84	22,903,695.57
20	Татварын дараах ашиг (алдагдал)	131,730,460.60	206,133,260.16
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	298,686,159.80	206,133,260.16
24	Орлогын нийт дүн	298,686,159.80	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,266,454,755.71	2,442,742,959.83
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,177,405,784.93	2,315,870,079.68
1.1.6	Бусад мөнгөн орлого	89,048,970.78	126,872,880.15
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,296,060,088.52	2,378,151,950.57
1.2.1	Ажиллагчдад төлсөн	805,968,710.08	906,195,245.33
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	212,679,756.27	247,571,047.24
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	255,239,452.00	325,667,014.0
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	431,231,672.94	472,905,829.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	57,873,074.00	59,284,000
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	317,339,491.46	289,105,955.22
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	6,495,147.00	5,486,020.0
1.2.8	Бусад мөнгөн зарлага	209,232,784.77	209,232,784.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(29,605,332.81)	64,591,009.26
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,598,200.00	
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,598,200.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,598,200.00)	
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(51,203,532.81)	64,591,009.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,523,907.00	3,320,374.19
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,320,374.19	67,911,383.45

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	3,376,672,260.78	59,760,414.97	-	(1,584,620,180.53)	1,851,812,495.22
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	54,122,996.45	54,122,996.45
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	206,133,260.16	206,133,260.16



5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	10,898,196.84	-	25,880,000.00	-	36,778,196.84
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
9	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	3,387,570,457.62	59,760,414.97	25,880,000.00	(1,192,633,463.32)	2,280,577,409.27

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан
(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-	Хувь
Үйл ажиллагааны орлого	2,753,565,626.0	2,638,010,731.66	115,554,894.3	96%
Түрээсийн орлого			-	
ОРЛОГО	2,753,565,626.0	2,638,010,731.7	115,554,894.3	
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	
1.3 Нийт ашиг	2,753,565,626.00	2,638,010,731.66	115,554,894.34	96%
Үндсэн үйл ажиллагаа				
Цалин	951,106,080.0	1,037,060,332.78	(85,954,252.8)	109%
Байгууллага төлөх НДШ	134,097,842.4	247,571,047.24	(113,473,204.8)	185%
Бичиг хэрэг	10,575,500.0	5,120,170.00	5,455,330.0	48%
Харилцаа холбоо	20,396,000.0	17,771,878.00	2,624,122.0	87%
Сургалтын төлбөр	18,000,000.0	17,016,000.00	984,000.0	95%
Сэлбэг багаж хэрэгсэл	108,122,200.0	66,999,700.00	41,122,500.0	62%
Хөдөлмөр хамгаалал	99,380,000.0	47,244,000.00	52,136,000.0	48%
Шатахуун	64,080,000.0	59,200,000.00	4,880,000.0	92%
Ариутгалын бодис	51,520,000.0	26,903,250.00	24,616,750.0	52%
Зээлийн хүүгийн төлбөр	128,504,204.0	-	128,504,204.0	0%
Цахилгааны зардал	503,287,200.0	454,893,951.67	48,393,248.3	90%
Дулааны зардал	58,329,600.0		58,329,600.0	0%
Зар сурталчилгааны зардал	2,000,000.0		2,000,000.0	0%
Гадны үйлчилгээний хөлс	18,780,000.0	25,814,918.80	(7,034,918.8)	137%
Гамшгийн зардал	44,775,000.0	-	44,775,000.0	0%
Засвар үйлчилгээний зардал	136,000,000.0	82,794,302.14	53,205,697.9	61%
Элэгдэл хорогдлын зардал	320,000,000.0	323,975,318.58	(3,975,318.6)	101%
Ажилчдын нийгмийн зардал	3,700,000.0	9,765,250.00	(6,065,250.0)	264%
Татвар даатгалын зардал	28,150,000.0	5,200,020.00	22,949,980.0	18%
Нууцын зардал	5,950,000.0		5,950,000.0	0%
Бусад	17,600,000.0	4,547,332.29	13,052,667.7	26%
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	2,724,353,626.40	2,431,877,471.50	292,476,154.90	89%
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	29,211,999.60	206,133,260.16	-	706%
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	29,211,999.60	206,133,260.16	-	706%
Татвараас чөлөөлөгдөх зардал				
Татвар төлөх ашиг алдагдал	29,211,999.60	206,133,260.16	176,921,260.56	7.06
3.1 Орлогын татварын зардал			-	
4. Татварын дараах ашиг алдагдал	29,211,999.60	206,133,260.16	-	7.06

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулагдаагүй нийт 11,284.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 11,284.3 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрч зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай он дамнасан 36,017.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах, 241,057.4 мянган төгрөгийн аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлага бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд байгаа өмнөх онуудын авлагыг барагдуулан зөрчлийг арилган ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд 8,704.3 мянган төгрөгийн компьютер, багаж хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авч байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөс 2,580.0 мянган төгрөгийг ажилчдын шинэ жилийн арга хэмжээ, шагналд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг шагнал урамшуулалд зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланд нэгээс дээш жилийн насжилттай он дамнасан 36,017.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах, 241,057.4 мянган төгрөгийн аж ахуйн нэгж, байгууллагаас авах авлага бүртгэлтэй байна.	1	-	-	-	1	-	-	-
Тайлант онд 8,704.3 мянган төгрөгийн компьютер, багаж хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	8,704.3	-	-	1	8,704.3	-	-
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын төсвөөс 2,580.0 мянган төгрөгийг ажилчдын шинэ жилийн арга хэмжээ, шагналд зарцуулсан байна.	1	2,580.0	-	-	1	2,580.0	-	-
Дүн	3	11,248.3	-	-	3	11,248.3	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			